



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/577

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан “МВМ сор” ХХК-тай 198,700,000 (нэг зуун ерэн найман сая долоон зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авах, хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “МВМ сор” ХХК-ийн захирал (О.Түвшинтөр)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ТҮРЭВ-ОЧИР



6325010796

09
А/.....
1577

Аймгийн Засаг даргын 2025 оны
дүгээр сарын 09-ныгний өдрийн
дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

№	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	12 сар	Д.Эрдэнэбилэг
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Б.Ариунболд
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
5	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоног	Д.Эрдэнэбилэг